

Олон улсын
харилцаа,
гадаад бодлого

Монгол Улсын стратегийн сонголт*

Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх,
Элчин сайд **Л. Эрдэнэчулуун**

Аль нэг орны хөршүүдтэйгээ болон бусад оронтой харилцах харилцааны стратеги хийгээд тухайн орноос олон улсын чанартай өргөн хүрээний асуудалд хандах хандлагыг тодорхойлох хүчин зүйл нэг бус байдаг. Тэдгээрээс хэдхэнийг дурьдвал: тухайн орны нутаг дэвсгэр, хүн ам, газар зүйн байршил, эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадал болон уг бүс нутгийн улс төр, аюулгүй байдлын орчин, хөрш орнуудын цэрэг зэвсгийн бодлого хийгээд улс төрийн ерөнхий уур амьсгал зэргийг нэрлэж болох юм. Энэ хүчин зүйлүүдийн учир холбогдол нь орон тус бүрт болон бүс нутаг тус бүрт харилцан адилгүй байдаг.

Монгол улсын хувьд ч тус орны газар зүйн байршил нь бусад олон орны нэгэн адил, түүний гадаад, дотоод бодлогын бүхий л цогцлогод нөлөөлдөг гол зүйлийн нэг юм. Монгол нь хоёр их гүрэн, нэрлэбээс Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд хавчуулагдан оршдог, ийм байршилтай маш цөөн улс орны нэг юм. Хөрш хоёр их гүрэн аль аль нь цөмийн зэвсэгтэй бөгөөд хоёулаа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орон юм. Монгол улс далайд шууд гарах гарцгүй цөөхөн орны нэг бөгөөд байгалиас заяасан энэхүү хувь тавилан нь гачлан зовлон нэмэрлэнэ үү гэхээс нимгэлдэггүй гэж болно.

Харьцангуй уудам газар нутагтай, цөөхөн хүн амтай, эдийн засаг нь шилжилтийн шатанд байгаа, дэд бүтэц нь дөнгөж хөгжиж яваа Монгол улс одоохондоо гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхолыг татах газар хараахан биш бололтой. Хэдий тийм боловч тус орны эрчимтэй бөгөөд туйлбартай хөгжлийн хэтийн төлөв нь Монголыг дэлхийн бусад хэсэгт буюу дэлхийн бусад хэсгийг Монголд нээж өгсөн шинэ эрин зууны гараа болж байна.

Монгол улсын стратегийн хүрээлэн буй орчин өнөөдөр эрс өөрчлөгдлөө. Түүний ирээдүйн хөгжлийн төрх төлөвт ихээхэн нөлөөлсөн зүйл бол хуучин ЗСБНХУ-ын өөрчлөн

*Энэхүү өгүүлэлд дурдсан тайлбар, хийсэн ажиглалт нь цөм зохиогчийн хувийнх учир ямар нэгэн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

байгуулалт, ил тод байдал, их улсын уналт ба тусгаар тогтносон арван таван улс болж задарсан явдал юм. Энэ үйл явдлын хаялага манай оронд тэр дороо ирж ардчилсан хөдөлгөөнийг дүрэлзүүлж, улмаар цус урсгалгүй төрийн эргэлт хийх нөхцлийг бүрдүүлж, 70 шахам жил тогтносон коммунист дэглэмийг унагасан юм. Эдгээр үйл явдал тус хоёр улсын харилцааг орчин үеийн олон улсын хууль зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний дагуу цоо шинээр авч үзэх боломж олгосон юм.

Монгол улс ба БНХАУ-ын хувьд гэвэл урьд оршиж байсан үзэл суртлын сөргөлдөөний саад тотгорыг эцэс болгосноор тус хоёр орны харилцаа бүрэн хэвийн байдалд орлоо.

Орос болон БНХАУ-тай харилцах Монгол улсын харилцааны үндсэн зарчмууд эдгээр улстай 1993, 1994 онд байгуулсан найрсаг харилцаа ба хамтын ажиллагааны гэрээнүүдэд тодорхойлогдсон байдаг.

Орос, Хятадын харилцааны төлөв байдал Монголд шууд нөлөөлөхөөр барахгүй бүс нутгийн болон дэлхий дахины аюулгүй байдалд бүхэлд нь нөлөөлнө гэдэгт эргэлзэх явдалгүй юм. Тийм ч учраас стратегийн түншлэлд дэвшин орох зорилт бүхий энэ хоёр орны харилцааны өрнөлт нь харилцан сонирхсон асуудал болон бүс нутаг, олон улсын чанартай асуудлаар гурван талт хамтын ажиллагааг өрнүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт найдлага тавих учиртай.

Бүхэлд нь авч үзвэл өнөө үеийн геополитик өөрчлөлтүүд хийгээд бусад оронтой, ялангуяа нөлөө бүхий орнуудтай өргөжиж байгаа Монгол улсын хэлхээ холбоо нь тус орон дотоодын болон олон улсын чанартай үйл ажиллагааныхаа аль алинд нь нэлээд бие даасан чиг шугам баримтлах нөхцлийг бүрдүүлж байна.

Монголын аюулгүй байдлын ирээдүй нь өөрийн хоёр хөрштэйгээ харилцах харилцаа, мөн тэдгээрийн хоорондын харилцаанаас ихээхэн шалтгаалах нь мэдээж юм. Нэлээд өргөн утгаар нь авч үзвэл том улсуудын хоорондын харилцаа, өөрөөр хэлбэл, Орос, Хятад, Япон, Америкийн Нэгдсэн Улсын харилцаанаас шалтгаална гэсэн үг юм. Түүнчлэн Монгол улсын өөрийнх нь баримталж байгаа бодлого, олон улсын нийгэмлэгт нэгдэн орох ур чадвараас багагүй шалтгаална.

Дотоод гадаадын шинэ бодит байдлыг тусгасан Монголын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 оны зургадугаар сард батлагдсан.

Энэ баримт бичиг үндэсний аюулгүй байдалд нэлээд цогцоор хандаж, Монголын үндэсний язгуур эрх ашгийг төв болгон тусгасан юм. Монголын аюулгүй байдлыг урьдын адил бидний сэтгэхүйг хэт цэрэг зэвсэгжүүлэх юмуу эсвэл мянга мянган иргэдээ үзэл баримтлалын хувьд найдваргүй этгээдэд тооцон амь насыг нь хөнөөж байсан тэр гунигт үеийн үзэл суртлын сөргөлдөөний нүдээр шүүх цаг нэгэнт өнгөрсөн байна. Манай үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан язгуур эрх ашиг нь Монголын ард түмэн, түүний соёл иргэншил, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн үл халдах дархан байдал, эдийн засгийн харьцангуй биеэ даасан байдал, экологийн тэнцвэр бүхий тогтвортой хөгжил, үндэсний нэгдэл зэргээс урган гарч байгаа тийм л эрх ашиг юм. Үндэсний эдгээр чухал эрх ашиг нь үзэл баримтлалд цохон тэмдэглэсэнчлэн төр ба ард түмний зүгээс онцгойлон хайрлан хамгаалж байх ёстой зүйлүүд мөн.

Үндэсний аюулгүй байдлын гол бүрэлдэхүүн хэсэг нь дараах 9 зүйлд хуваагдаж байна. Үүнд:

1. Монгол улсын оршин тогтнолын аюулгүй байдал,
2. Нийгмийн хэв журам болон төрийн байгууллын аюулгүй байдал,
3. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал,
4. Эдийн засгийн аюулгүй байдал,
5. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал,
6. Мэдээллийн аюулгүй байдал,
7. Монгол соёл, иргэншлийн аюулгүй байдал,
8. Хүн ам ба түүний удмын сангийн аюулгүй байдал,
9. Экологийн аюулгүй байдал эдгээр болно.

Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох гадаад дотоод хүчин зүйлүүд болон болзошгүй заналхийлэлтэй тэмцэх арга замыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гол бүрэлдэхүүн хэсэг бүрт тодорхой заажээ. Урьдчилан сэргийлэх механизм юмуу болзошгүй заналхийллийг багасгах арга барилын заалтууд нь үзэл баримтлалын нэг онцлог шинж болно.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад эрх баригч байгууллагууд, улс төр болон олон нийтийн байгууллагын

гүйцэтгэх үүргийг тус үзэл баримтлалд нэгэн адил тодорхойлсон байна.

Эрс өөрчлөгдөж буй бүс нутгийн болон дэлхий дахины нөхцөл байдалтай уялдуулж Монгол улсын стратегийн сонголтыг дараах байдлаар төсөөлж байна. Миний бодлоор ардчиллалын замаар замнасан хүмүүнлэг нийгэм, зах зээлийн эдийн засагтай монгол улсын ирээдүйн хөгжилтөд гарцаагүй шаардагдах стратегийн сонголт наад зах нь доор дурьдаж буй таван чиглэлээр байх учиртай.

-Ийм сонголт нь юуны өмнө тус орны хоёр том хөрш болно. Хоёр хөршийнхөө аль алинтай нь эвсгээр харилцаж, харилцан сонирхсон бүх асуудлаар нягт бөгөөд итгэлтэй үйл ажиллагаа явуулах нь нэн чухал юм. Үүний сацуу гурван талт яриа хэлцээний механизм бий болгож, гурван орныхоо эрх ашигт шууд холбогдох асуудлыг тунгаан хэлцдэг хэвшил тогтвол тэр нь хоёр талын харилцаанаас ч дутахгүй чухал ач холбогдол бүхий юм. Тийм хэлцээний ширээн дээр өөрийн бүсийн хэтийн төлөв, одоогийн хандлагыг авч үзэн, аюулгүй байдал-хүрээлэн буй орчин-эдийн засаг-худалдаа-бусад холбогдох асуудлыг тал талаас нь тунгаан хэлэлцдэг болмоор байгаа юм. Сүүлийн жилүүдэд Хятад манай хоёрын харилцаа өндөр төвшинд хүрч цаашдаа улам нягт, харилцан үр ашигтай хамтран ажиллах зам нээгдлээ. Харин тийм дүгнэлтийг зарим нэгэн өрөөсгөл, тэнцвэргүй байдал оршсоор байгаа Орос манай хоёрын харилцааны хувьд хэлж хараахан болмооргүй байна. Иймэрхүү ялгаатай байдлыг тэнцүүлэх нь (харилцааны давтамж ба төвшний хувьд) хэн хэнийхээ санаа бодлын талаархи буруу зөрүү ойлголтыг нэгэн тийш болгоход тус дөхөм үзүүлэх нь эргэлзээгүй.

-Манай үндэсний эрх ашиг түүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох урьдчилан харж боломгүй хэрэг явдлын өрнөлтийг намжаах зорилгоор бага буурай Монгол мэтийн оронд, нийт жижиг улс үндэстэнд байдгийн нэгэн адил, хил нийлсэн хөршүүдтэйгээ харилцах харилцааг нь тогтворжуулах үүрэг гүйцэтгэх аль нэгэн гуравдагч хөрш сонгож олох нь зүйн хэрэг юм. Санаагаар болдогсон бол Орос, Хятад хоёрын алинтай нь ч эн дүйцэм оршин тогтнохуйн тэнцвэржлийг бий болгох тийм л орон тохиромжтой юм. Гэтэл тийм санаа лав л ойрын ирээдүйд биелэгдэх зүйл биш юм. Энэ талаар миний өөрийн бодол бол гуравдагч хөрш нэг л орон байх ёстой мэт үздэг манай зарим улс төрчдийнх шиг биш харин нэг хэсэг

орон, ялангуяа Монгол дахь ардчилсан өөрчлөлтүүдийг тууштай дэмждэг орнууд байгууштай. Энэ талаар дэлхийн эдийн засгийн зангирмал хүч бөгөөд улмаар дэлхий дахины үйл хэргийг гүйцэтгэх улс төрийн үүрэг нь нэмэгдэж буй Япон (манай хамгийн том хандивлагч)-ыг онцлон дурьдаж болох юм. Өнөө үед манай оронд тулгаран буй хүнд хүчир шилжилтийн бэрхшээлийг гэтлэн давж, нийгэм эдийн засгийн хүндрэлийг зөөлрүүлэхэд Япон улсын идэвхтэй бөгөөд бүхий л талын оролцоо зайлшгүй чухал. Мөн хүрээнд Герман улсын эзэлж буй байр суурь нэгэн адил ач холбогдолтой юм. Мөн манай цөөн бус улстөрч, төр засгийн албан хаагчдын бодлоор шинэ Монголыг аврагч, түүний үндэсний аюулгүй байдлын гол түшиг тулгуур” нь АНУ гэж үзэх нь бий. Иймэрхүү гэнэн найдвар нь бас ч аргагүй, ойлгомжтой юм. Ялангуяа түгшүүртэй юмуу хямралтай нөхцөлд аливаа жижиг улс үндэстэн аль нэгэн хүчирхэг хөршөө бараадах тохиолдол байдаг билээ. Тийм үед хоёр этгээдийн аль уршиг багатайг нь сонгодог аж. Харин Монголын хувьд бол энэ зууны сүүлчийн арван жил олон тооны эерэг хүчин зүйл хайрлаж, аюулгүй байдлаа бэхжүүлэх маш олон янзын сонголт хийх боломж олголоо. Улс төрийн хүрээлэн буй орчин ихэд сайжирсан өнөө үед Орос юмуу Хятадтай харилцаагаа золих замаар АНУ нь Монголтой тийм ч дорвитой харилцаанд ороход бэлэн биш болов уу гэж үүнийг бичигч үзэж байна. Гэхдээ энэ бол хоёр улс цэрэг батлан хамгаалах салбарт янз бүрийн төвшинд хамтран ажиллах, мөн боловсрол, иргэний цэргийн харилцаа, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ зэрэг “төвийг сахисан” асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулахад саад боомт болдоггүйг 1996 онд байгуулагдсан “Монголын засгийн газар АНУ-ын засгийн газрын хооронд цэрэг солилцох, харилцан айлчлал хийх тухай хэлэлцээр” харуулж байна.

-Монголын аюулгүй байдлыг цаашид бэхжүүлэх нэгэн бодит чухал хүчин зүйл бол түүний бүс нутгийн бүтцэд болон бүс нутаг ба дэлхийн эдийн засагт аль болох шуурхай өргөн хэмжээгээр сүлэлдэх явдал юм. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын компаниудын оролцоог идэвхжүүлж, тэдгээрийн сонирхлыг монголын цаашдын тогтвортой хөгжил, түүний аюулгүй байдлыг хангахад нэмэгдэл хүчин зүйл болгох учиртай. АПЕК-т яваандаа гишүүнээр элсэх явдал энэ зорилтыг биелүүлэхэд тусална. Өнөөгийн байдлаар Монгол нь АПЕК-ийн зарим ажлын хэсэгт /эрчим хүч,

худалдааг дэмжих зочны журмаар оролцож байгаа юм. Тээвэрлэлт, аялал жуулчлалын ажлын хэсэгт элсэх өргөдлөө өгсөнөөс гадна хүн хүчний нөөцийн хөгжлийн ажлын хэсэгт оролцох сонирхолтой юм.

-1993 онд байгуулагдсан АСЕАН-ы бүсийн чуулга уулзалт /АРФ/ нь Ази-Номхон далайн нийт бүс нутгийн аюулгүй байдлын асуудлуудыг хэлэлцэж байгаа учир Азийн орнуудын анхаарал, ялангуяа уг хэлцээнд багтаагүй улсуудын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тийм яриа хэлцээ илүү үр ашигтай байхын тулд уг бүс нутгийн улс орныг өргөнөөр хамарч, тэдний санаа бодлыг авдаг болох нь чухал юм. Монгол улс энэ хэлцээнд оролцох сонирхлоо нэг бус удаа илэрхийлж ирсэн. Цаашилбал, бүсийн аюулгүй байдлын талаар эрдэм шинжилгээний хүмүүс болон засгийн газрын төлөөлөгчид оролцсон холимог хэсгээс бүрдсэн “ТРЭК 2” гэж нэрлэдэг хэлцээний дипломатын хэлбэрийг цаашид үргэлжлүүлж дээрх асуудлыг албан бус маягаар хэлэлцэж байх шаардлагатай гэж үзэж байна. Зүүн хойд Азийн салбар бүсэд мөн харьяалагддагийн хувьд Монгол улс нь уг салбар бүсийн бүх орнуудыг хамаарсан асуудлыг хэлэлцэж байх салбар бүсийн хэмжээнд яриа хэлцээ хийхийг сонирхож байдаг юм. Гэхдээ энэ асуудлыг сонирхогч орнуудын дийлэнх олонхийн санал, тэр байтугай заримынх нь хардлага сэрдлэг мэтийг хүртэл тооцон, тал бүрийн нарийн судалгаанд тулгуурлан, алхам алхамаар ахиулж шийдэх нь зүйд илүү нийцтэй болно гэж үзэж байна.

-Монгол улс нь Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөний гишүүн, 77 бүлэг /Б-77/-ийн гишүүний хувьд дэлхийн энэхүү томоохон бүлэглэлийн улс төрийн жин, үр нөлөөнд ихээхэн итгэл, найдвар өгдөг юм. Дэлхийн орнуудын 70 гаруй хувийг эгнээндээ багтаасан эдгээр бүлэглэлүүд нь ирэх зуунд ч гэсэн дэлхий дахины үйл хэрэгт улам их үүрэг гүйцэтгэх учиртай бөгөөд тэр эрхэм үүргээ нэр төртэй биелүүлнэ гэж найдаж байна.

-Геополитикийн орчин тойрон өөрчлөгдөж олон туйлт, олон талт бодлого өнөөгийн хэм хэмжээ болсон энэ эрин үед дэлхийн улс төрийн бодлогын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход НҮБ-ын гүйцэтгэх үүрэг цаашид улам бүр нэмэгдэх болно.

Монгол мэт жижиг улс үндэстэнд НҮБ нь эрх чөлөө, тусгаар тогтнолын нэг чухал улс төрийн баталгаа болох учиртай.

Монгол улс хөгжлийнхөө шинэ үе шатанд орлоо. Энэ үе шат түүнд өргөн боломж нээж өгч байгаагийн сацуу том том шийдвэрлэх асуудлыг үүдэж байна. Миний үзэж байгаагаар гол ололт бол Монгол өөрөө өөрийгөө таньж ойлгон, эргэн тойрондоо юу болж буйг өөрийн нүдээр харах боломжтой болсон явдал юм.

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын гол зарчмууд тэрчлэн цэргийн номлолын үндэс нь Монгол өөрийгөө болон бусдыг таньж ойлгосон шинэ үзлийн тусгал болж байна. Тэдгээр үзэл баримтлал нь чулуунд сийлсэн, өөрчлөгдөшгүй зүйл биш бөгөөд монголын дотоодод болон гадаад ертөнцөд буй болж байгаа өөрчлөлтүүд нь тэдгээр баримтлалыг зохих хэмжээгээр өөрчлөх болно. Ийм утга санаа ч дээрхи баримтлалуудад тусгагдсан юм. Эдгээр баримтлалууд эдүгээ нэгэнт нийтлэгдсэн учир хэдүйнээ уншигчдын хүртээл болсон билээ.

Англи хэлнээс орчуулсан Э.Пунцаг

(Энэ өгүүллийн эхийг "The Mongolian journal of international affairs" Сэтгүүлийн №5-д үзнэ үү).

**Монгол улсын геополитик, хөгжлийн
1990-ээд оны онцлог**

Элчин сайд Х.Олзвой

**Нэг. Монгол улсын геополитикийн
өвөрмөц тал.**

Аливаа улсын газар зүйн байршил нь тэр орны хөгжил, гадаад харилцаа, аюулгүй байдал, их гүрнүүдийн бодлогод гүйцэтгэх үүргийг тодорхойлдог. Монгол бол бүр ч өвөрмөц онцлогтой орон. Яагаад вэ гэвэл:

1.Далайд гарцгүй, гэхдээ хүрээлдэг хоёр орон нь хүч тэнцвэргүй аваргууд учир далайд гарцтай болох эрхээ баталгаажуулж ч чадаагүй байсан.

2.Цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн, тэгэхдээ бүр коммунист хоёр хөршийнхөө үзэл суртлын маргаанд ч өртөхөөр бодлогыг эрх баригчид нь явуулж байсан болохоор үй